



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 820

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 14 зүйлийн 2 дахь хэсгийн 4, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.2, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн их сургууль (5 бүрэлдэхүүн сургууль, 1 нэгж)-ийн албан хэрэгцээнд зориулан өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 2021 онд нийт 500,000,000.00 (Таван зуун сая) төгрөгт багтаан үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрч, санхүүжилтийн дүн, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Хөдөө аж ахуйн их сургуулийн захирал Т.Хэрүүгад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс(Д.Нарангэрэл)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



13201770

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 720 дугаар тогтоолын хавсралт

ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ (БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ, НЭГЖ)-ИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР ОЛЖ АВАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Эргэлтийн бус хөрөнгийн төрөл, нэр	Хэмжих нэгж, тоо хэмжээ	Барьж эхэлсэн (эхлэх) он	Нийт төсөвт өртөг (төгрөг)	2021 онд зарцуулах санхүүжилтийн дүн (төгрөг)
1. Барилга байгууламж, их засвар, өргөтгөл					
1	Эдийн засаг, бизнесийн сургуулийн номын сангийн өргөтгөлийн 5 давхар барилга	1	2017-08-15	1,500,000,000.00	200,000,000.00
2	Мал эмнэлгийн сургуульд Өлзийт хорооллын газарт Том малын үзлэгийн байр барих /дадлага, хичээл практик/	1	3//2021	60,000,000.00	60,000,000.00
3	Хөдөө аж ахуйн их сургуулийн хичээлийн төв байрны дээврийн их засвар		2021-03-15	100,000,000.00	100,000,000.00
ДҮН					360,000,000.00
2.Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж					
4	380кв-ийн цахилгаан дамжуулах цогц шийдэл /УБ хотоос 130км зайд байрлах Төв аймгийн Борнуур суманд байрлах ХААИС-ийн Нарт сургалт судалгааны төвийг ЦЭХ-ээр хангах зардал	ш	1	100,000,000.00	100,000,000.00
5	Суурин компьютер /багш нарт/	ш	10	20,000,000.00	20,000,000.00
ДҮН					120,000,000.00
3. Тавилга,эд хогшил, бусад үндсэн (биет бус) хөрөнгө					
6	Оюутны сандал	ш	50	150,000.00	7,500,000.00
7	Оюутны ширээ	ш	50	250,000.00	12,500,000.00
ДҮН					20,000,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН					500,000,000.00
				500,000,000.00 (таван зуун сая)	